



**ОРХОН АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 12 дугаар сарын 31

Дугаар 02/23

Жаргалант сум

**Боловсрол хөтөлбөр болон хөтөлбөрийн
2025 оны төлөвлөгөө батлах тухай**

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 49 дүгээр зүйлийн 49,1 дэх хэсгийг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Боловсрол хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийн 2025 оны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг Засаг дарга (Л.Учрал)-д үүрэг болгосугай.


ДАРГА



Ш.БИЛГҮҮНБААТАР

1024010089

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны
12 дугаар сарын 31-ний ээлжит III хуралдааны
02/23 тогтоолын нэгдүгээр хавсралт



“БОЛОВСРОЛ” ХӨТӨЛБӨР

НЭГ.ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ

“Боловсрол” хөтөлбөрийг Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Чадварлаг багш хөтөлбөр, Орхон аймгийн нийгэм, эдийн засгийг 2024-2028 онд хөгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Орхон аймгийн Жаргалант сумыг 2024-2028 онд хөгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Сургууль, цэцэрлэгийн стратеги төлөвлөгөө зэрэг Монгол Улсын хөгжлийн бодлого, стратеги, урт болон дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөг тодорхойлсон баримт бичгийн үзэл санаа зарчимд үндэслэн боловсруулав.

“Боловсрол” хөтөлбөр нь сумын Засаг даргын 2024-2028 онд хөгжүүлэх мөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны үндсэн чиглэлд тусгагдсан боловсролын талаар баримтлах бодлого, үйл ажиллагааг бүхэлд нь тусгасан баримт бичиг бөгөөд мөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны үндсэн чиглэлийн салшгүй хэсэг мөн.

Боловсрол хөтөлбөр нь сургууль, цэцэрлэгийн **Дунд хугацааны болон жил, сарын үйл ажиллагааны төлөвлөгөөний** үндсэн хэсэг байх бөгөөд хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг сургууль, цэцэрлэгийн **бүх шатны ажлын төлөвлөгөөнд** тусгаж хэрэгжүүлэхийг тухайн байгууллагын **удирдлагууд шууд хариуцна.**

Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий Засаг даргын тамгын газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг ажиллаж хэрэгжилтийг Засаг даргад улирал бүр тайлагнана.

ХОЁР.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЗАРЧИМ

Хөтөлбөрийн зорилго: “Боловсрол” хөтөлбөрийн (цаашид “Хөтөлбөр” гэх/) зорилго нь Жаргалант сумын боловсролын байгууллагад тулгамдаж буй асуудлыг судлан илрүүлж, шийдвэрлэх арга замыг сонгон сургалтын таатай орчин, багш, ажилтан, сурагчид тасралтгүй хөгжих нөхцөл бүрдүүлэх, хүүхдийг хөгжүүлдэг багшийг төлөвшүүлэх, тэргүүн туршлагыг түгээх, нэр хүнд нийгмийн баталгааг нь хангахад оршино.


Хөтөлбөрийг зорилтууд:

- 1.Боловсролын байгууллагын гол хөдөлгөгч хүчин болсон **багшлах боловсон хүчний** мэдлэг, боловсрол, заах арга зүйн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, багш, ажилтны эрүүл мэндийг хамгаалах, тэдний нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлэх.
- 2.Боловсролын үйлчилгээний үндсэн хэрэглэгч болсон **суралцагчдын** сурч хүмүүжин,хөгжих үндсэн хэрэгцээг хангах, тэдний үйл ажиллагаа, оролцоонд дэмжлэг үзүүлэх.
- 3.Боловсролын үйлчилгээний оролцогч, дэмжигч субект болох **эцэг эхийн** идэвхи, оролцоог дэмжих.
- 4.Багш, ажилтны нийгмийн баталгааг хангах, ажиллах орчин нөхцлийг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтлана:

- ✓ Хөтөлбөр нь сурагч, эцэг эхчүүдийн хэрэгцээ, шаардлага багшийн хөгжлийн түвшин, эрэлт хэрэгцээ, сонирхол, боломж, итгэл үнэмшилд тулгуурлах
- ✓ Боловсролын тухай хууль болон холбогдох баримт бичиг, хөтөлбөртэй нийцсэн байх
- ✓ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь нээлттэй, хүртээмжтэй уян хатан, чанартай байх

- ✓ Хөтөлбөр нь олон улсын хөгжлийн чиг хандлага, үндэсний болон орон нутгийн онцлогт нийцсэн байх
- ✓ Төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн оролцоо, иргэд гадаадын хандивлагч, сонирхогч бүх талын дэмжлэгт түшиглэх
- ✓ Мэдээлэл, харилцааны технологийн ололт амжилтыг ашиглах



ГУРАВ.ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

Хөтөлбөрийг сумын нийгэм, эдийн засгийг 2025-2028 он хүртэл хөгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөний хугацаатай уялдуулан 2025-2028 онд хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ.ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээр санхүүжүүлнэ.

1. Улсын болон орон нутгийн төсөв
2. Төрийн бус байгууллагуудын дэмжлэг, хандив
3. Гадаад дотоодын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр
4. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдийн нийгмийн хариуцлагын хүрээн дэх үйл ажиллагаа, хандив, дэмжлэг
5. Иргэд, олон нийт, эцэг эхчүүдийн хандив зэргээс бүрдэнэ.

ТАВ.ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хөтөлбөрийг дараах байдлаар зохион байгуулна:

Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий **АЖЛЫН ХЭСЭГ** ажиллаж хэрэгжилтийн явц үр дүнг улирал бүр сумын Засаг даргад тайлагнаж, улирлын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж Засаг даргаар батлуулж үүрэг чиглэл авч ажиллана.

АЖЛЫН ХЭСЭГ: Хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах бодлого, эрх зүйн орчин бүрдүүлэх, иргэд, иргэний нийгмийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоо, уялдаа холбоог хангах, хөтөлбөрийн улирлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, хэрэгжилтийн явцад хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, санхүүжилтийн асуудлыг Сумын ИТХ, орон нутгийн Засаг захиргаа, байгууллагын захиргаанд уламжлан шийдвэрлүүлэх асуудлыг хариуцна.

ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ХЭЛБЭР: Хөрөнгө оруулалт, сургалт, туршлага судлах, хүүхэд нэг бүрийг хөгжүүлж буй тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, Багш, сурагч, эцэг эхийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хэлбэрээр зохион байгуулагдана.

ЗУРГАА.ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖСЭНЭЭР ГАРАХ ҮР ДҮН

- ✓ Ажлын байран дээрээ мэргэжлийн ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг, бүрдүүлсэн **БАГШИЙН ХӨГЖЛИЙН ТӨВТЭЙ** болж, багш солилцооны үр дүнд сургалтын шинэлэг арга, тэргүүн туршлагаар дэмжсэн байна
- ✓ Хүүхэд нэг бүрийн авьяасыг нээн хөгжүүлэх чиглэлээр тэргүүний туршлагатай багшийн тоо нэмэгдэнэ.
- ✓ Хүүхэд нэг бүрийн авьяасыг нээн илрүүлэн, хөгжүүлэх чиглэлээр багш нар **ХӨТӨЛБӨР** боловсруулж цахим мэдээллийн сүлжээнд байршуулан, хэрэгжүүлдэг болсон байна.
- ✓ Сургалтын чанарт ахицтай байхад багш, сурагч төдийгүй эцэг эхийн **ОРОЛЦОО, ХАНДЛАГА** нэмэгдсэн байна.
- ✓ Багш нарын мэргэшүүлэх түншлэлд суурилсан бүтэц, зохион байгуулат (загвар)-ыг бий болгож багш мэргэжлээ тогтмол дээшлүүлэх, эрдэм судалгааны ажил хийх, туршлагаа солилцох, хөгжих боломж өргөжсөн байна.

- ✓ Багш тасралтгүй суралцах, хөгжих таатай орчинг бүрдүүлсэн, сургалтын хэрэглэгдэхүүн, орчин нөхцөл, мэдээллийн санг стандартын түвшинд хүргэж, багшийг хөгжүүлэхтэй холбоотой цахим мэдээлэл, зайн сургалтын шинэ төрөл, технологиуд үйл ажиллагаанд нэвтэрч үр өгөөжөө өгсөн байна.
- ✓ Багшийн мэдлэг чадвар, авьяас, бүтээлч санаачлага, бие дааж хөгжих сонирхол, хүсэл эрмэлзэл сайжирч, багшийн ажлын нэр хүнд өсөж, тэднийг төр хувийн хэвшлийн бүх шатны байгууллага, иргэний нийгмийн байгуулал, ард иргэд бүх талаар дэмжих, хамтарч ажиллах сонирхолтой болсон байна
- ✓ Тогтвор суурьшилтай үр бүтээлтэй ажилладаг багш, ажиллагсдын нийгмийн асуудал шийдвэрлэгдсэн байна.
- ✓ Сургалт явуулах тохилог дулаан хичээлийн анги танхим, шаардлагатай хэрэглэгдэхүүн, туршилтын багаж зэргээр бүрэн хангагдаж сурагчдын сурах идэвх чармайлт эцэг эхчүүдийн сэтгэл ханамж дээшилж хамран сургах хүүхдийн тоо нэмэгдэнэ.
- ✓ Мэдээлэл, туршлагаа харилцан солилцдог, өөрсдийгөө хөгжүүлдэг мэдээллийн цахим сүлжээ байгуулан ажиллуулах замаар багш хамтдаа хөгжих нөхцөл, боломж бүрдэж, ажлын үр бүтээл аюулгүй байдалд хяналт тавих, өдөр тутмын хичээл сургалтын ажил чанартай зохион байгуулагдсанаар ахиц гарах бололцоог камержуулалт, дотоод сүлжээ зохион байгуулснаар бүрдсэн байна.


ДОЛОО.ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ

- Хөтөлбөрийн хэрэгжилтийг төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрэх үр дүн болон шалгуур үзүүлэлтийн биелэлтээр гаргана.
- Хөтөлбөрийн үнэлгээг жил бүрийн 12 сард тайлангаар авч цаашид хэрэгжүүлэхэд анхаарах санал, өөрчлөлт зэргийг ИТХ-ын хуралд тайланган дүгнүүлнэ. Шаардлагатай тохиолдолд хааж мөн засаж сайжруулж болно.


НАЙМ.ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилтууд	Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа				Шаардагдах санхүүжилтийн хэмжээ,эх үүсвэр	Хүрэх үр дүн
		2025	2026	2027	2028		
Нэг. Боловсролын байгууллагын гол хөдөлгөгч хүчин болсон багшлах боловсон хүчний мэдлэг, боловсрол, заах арга зүйн үр чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх	<p>1.1.Багш нарын идэвх оролцоог дэмжиж, арга зүй ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр:</p> <p>1.1.1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын нэрэмжит Багшийн ур чадварын болон Сурган хүмүүжүүлэх илтгэлийн уралдааныг жилд нэг удаа зохион байгуулж, эхний 3 байр эзэлсэн багш нарыг шагнаж урамшуулах.</p>					1.100.000	Багш нарын судалгааны ажил хийх чадвар дээшлэх, идэвх оролцоо нэмэгдэх.

1.1.2.Чадварлаг багш үзэсгэлэн зохион байгуулах					2.000.000	Багш нарын мэргэжлийн ур чадвар, бүлээлчээр сэтгэх хөгжүүлэх хичээлийн бэлтгэл, сайжрах, сургалтын чанарт ахиц гарна.
1.1.3.Аймгийн олимпиадад 1, 2, 3-р байранд, шалгарсан багшийг урамшуулах. (тухай бүрд)					3.200.000	Багш нарын онолын мэдлэг нэмэгдэх.
1.1.4.Улс, бүс чанартай урлаг, спортын уралдаан тэмцээнд өөрөө болон сурагчдыг амжилттай оролцуулсан багш, сурагчдад мөнгөн дэмжлэг үзүүлэх.					2.800.000	Багш сурагчдын идэвх оролцоо нэмэгдэх.
1.1.5.ЭЭШ-д амжилттай оролцож, 700 гаас дээш оноо авсан сурагчид, болон бэлтгэн багш нарт мөнгөн тэтгэлэг олгох.					3.450.000	Багш сурагчдын идэвх оролцоо нэмэгдэж, амжилттай оролцох системтэй бэлтгэх нөхцөл бүрдэнэ.
1.1.6.“Багш солилцоо -2026” зохион байгуулах (аймгийн, сургууль цэцэрлэг)					1.000.000	Багшийн мэргэжил арга зүйн чадвар сайжирна.
1.1.7.Сумын хөгжлийн чиглэлээр багш нарын дунд уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах					1.400.000	Багш нарын арга зүй дээшлэн, хамтын ажиллагаа сайжирна.
1.2.Багшийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр. 1.2.1.Эрүүл мэндийн үзлэг оношилгоонд нэгдсэн журмаар хамруулах,					9.400.000	Багш нарыг болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх.



төлбөрийн асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэх						
1.2.2.Багш, ажилтны эрүүл мэндийг хамгаалах зорилгоор улсын чанартай рашаан сувиллын газартай гэрээ байгуулан хамтран ажиллах, сувилуулах зардалд хөнгөлөлт үзүүлэх. (Жилд 1-2 багш ажилтан)					2,800,000	Багш нарыг болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх.
1.2.3.Багш ажилтны хүн амын дунд зонхилж буй өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт тогтмол зохион байгуулах					4.400.000	Багш, ажилтны эрүүл мэндийн боловсрол дээшлэх.
1.2.4.Багш ажилтанд сэтгэл зүйн үйлчилгээ, сургалт дэмжлэг үзүүлэх					2.400.000	Сэтгэл зүйн таатай орчин бий болно.
1.3.Багшийн нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлэх чиглэлээр:						
1.3.1. Хандлага, ёс зүйн чиглэлээр БМДИ-с мэргэжлийн багш урьж сургалт явуулах.					4.400.000	Багш нарын харилцаа хандлага, ёс зүйд эерэг хандлага гарах.
1.3.2.Хандлага, ёс зүй, хариуцлагатай байдлаараа тэргүүлсэн нэг багшийг жил бүр тусгай журмын дагуу шалгаруулж "Багш нарын баяр"-аар шагнаж урамшуулах					800.000	Багш нарын харилцаа хандлага, ёс зүйд ерэг хандлага гарах
1.3.3.Хичээлийн жилийн эцсээр Эрдмийн баярын үеэр БҮТЭЭЛЧ БАГШ НАРЫН ҮЗЭСГЭЛЭН гаргаж байр					800.000	Багш нарын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, хөхүүлэн дэмжих, сургалтын хэрэглэгдэхүү

	эзлүүлэн шагнаж урамшуулах.						ний баяжилтыг нэмэгдүүлэх		
	1.3.4.Өөрийн хүсэлтээр ирж ажиллаж байгаа багш, боловсон хүчинд журманд заасны дагуу дэмжлэг үзүүлэх.						4.400.000	Мэргэжлийн чадварлаг багшаар хангагдах, багшийн хомсдол арилах	
	1.3.5.Жил бүрийн багш нарын баярыг угтсан олон талт үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, багш мэргэжлийг олон нийтэд сурталчлах							2.000.000	Багшийн нэр хүнд, үнэлэмж дээшлэх
	1.3.6.Багш ажилтны ёс зүйн харилцаа хандлага, дээшлүүлэх, манлайллыг нэмэгдүүлэх олон талт ажил зохион байгуулах							2.400.000	Хандлага ёс зүй сайжирна.
Хоёр. Боловсролын үйлчилгээний үндсэн хэрэглэгч болсон суралцагчдын сурч хүмүүжин, хөгжих үндсэн хэрэгцээг хангах, тэдний үйл ажиллагаа, оролцоонд дэмжлэг үзүүлэх	2.1.Масс сургалтын стандарт хангалтын түвшинг ахиулах зорилгоор судлагдахуун бүрээр улирал бүр сургуулийн захирлын нэрэмжит ТТШ, хичээлийн жилийн улирал бүрийн сүүлийн 7 хоногт ТТШ, хичээлийн жилийн эцэст ТТШ-ыг тусгай удирдамжийн дагуу БГ-ын арга зүйчидтэй хамтран зохион байгуулж, сурлагаар тэргүүний анги шалгаруулж, Засаг даргын нэрэмжит шагналаар шагнаж урамшуулах.					800.000	Стандарт хангалтын түвшинд анализ хийх, чанартай сургалтыг дэмжих тогтолцоо бүрдэнэ.		

2.2. Улс, аймгийн уралдаан тэмцээнд оролцож амжилт гаргасан сурагчдад дэмжлэг үзүүлэх.					4.000.000	Сурагчдын идэвх оролцоо дээшилнэ.
2.3. Тусгай авьяас чадвар шаардсан дугуйлан секц явуулах багшийн цалин, хөлс болон бусад зардалд дэмжлэг үзүүлэх. (Сурагчдын хүсэл сонирхолыг харгалзан үзэж судалгаан дээр үндэслэн). Жишээ: Шатар, 100 буудалт даам, Морин хуур, бадминтон, Чөлөөт бөх, Хөл бөмбөг					4.000.000	Сурагчдын авьяас чадварыг нээн илэрүүлж хөгжүүлнэ.
2.4. Хүүхдийг хөгжүүлэх, сонгон секц, дугуйлан хичээллүүлэхэд шаардагдах сургалтын хэрэглэгдэхүүн авахад болон сонгон секцээр хүүхдийг хөгжүүлсэн багш нарт мөнгөн дэмжлэг үзүүлэх.					6.000.000	Сурагчдын авьяас чадварыг нээн илэрүүлж хөгжүүлнэ.
2.5. Орон нутгийн түүхэн дурсгалт газар, ард иргэдийн ёс заншилтай танилцуулах зорилгоор бага, дунд ангид тусгай хөтөлбөрөөр "ЭКО", "Музей" аялалыг жилд нэг удаа зохион байгуулах.					6.700.000	Сурагчид орон нутгаа таниж мэдэх, хайрлан хамгаалах үзэл төлөвшинэ.
2.6. Тайлан тоглолт, бүтээлийн үзэсгэлэн гаргасан сурагчдад санхүүгийн дэмжлэг үзүүлэх.					1.600.000	Багш сурагчдын авьяасаа нээн илрүүлэх нөхцөлыг бүрдүүлнэ.
2.7. Ахлах ангийн сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох					4.400.000	Ахлах ангийн сурагчдад мэргэжлээ зөв сонгоход

10 нэгж / 1000000
 10 сурагч / 1000000
 1000000 / 1000000

	сургалт, танилцах аялал зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.						дэмжлэг үзүүлнэ.
	2.8. Уншаад ойлгох чадвар хөгжүүлэх үйл ажиллагаа болон Дэвтэр сурагчын толь аян зохион байгуулах					1.000.000	Сурагчдын хөгжих үйл ажиллагааг дэмжих, суртчиоан таниулах.
	2.9. "Design school" хөтөлбөр					48.500.000	Суралцагч нарын компьютерийн мэдлэг чадвар нэмэгдэх
Гурав. Боловсролын оролцоог дэмжих. Үйлчилгээний оролцогч, дэмжигч субект болох эцэг эхийн идэвхи, оролцоо нэмэгдүүлэх	3.1. Сургууль цэцэрлэгийн "Эцэг эхийн зөвлөл"-ийн ажлыг эрчимжүүлж анги бүрийн эцэг эхчүүдийг хамарсан хүүхдийнхээ сурлага, хүмүүжил, урлаг, спортыг хөгжүүлэх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор улиралд 1 удаа сургалтад хамруулах					2.800.000	Эцэг эхийн зөвлөлийн ажлын үр дүнд ахиц гарна.
	3.2. Хүүхдийнхээ хөгжлийг дэмждэг, боловсролын үйл ажиллагаанд оролцдог "БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИГЧ ГЭР БҮЛ" -ийг шалгаруулах, урамшуулах АСТ, Өдөрлөг, уралдаан, тэмцээн зохион байгуулах					2.800.000	Эцэг эхийн зөвлөлийн ажлын үр дүнд ахиц гарна.
	3.3. Эцэг эх, хүүхдүүд нь хамтарсан ардын уламжлалт гар урлал, амьдрах ухааны чиглэлээр сургалт зохион байгуулах. (ардын биет болон биет бус өв тээгчдийн өвийг хүүхэд залууст өвлүүлэн						3.300.000



	уламжлуулах үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих)						
	3.4.Эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор сургуулийн нээлттэй хаалганы өдөр жилд 2 удаа зохион байгуулан ажиллах.					4.000.000	Эцэг эхийн идэвх оролцоог дэмжих сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх.
Дөрөв. Багш ажилтны нийгмийн баталгааг хангах, ажиллах нөхцлийг сайжруулах,хөрөнгө оруулалтын нэмэгдүүлэх.	4.1.Сургуулийн А Блокийн их засвар					990.000.000	Сургалтын таатай орчин бүрдэнэ.
	4.2.Мэдээлэл зүйн кабинет их засвар					67.300.000	Сурагчдын техник технологийн сурж хөгжих таатай орчин хөгжинэ.
	4.3.Мэдээлэл зүйн кабинетийн тоног төхөөрөмж					45.600.000	Сурагчдын техник технологийн сурж хөгжих таатай орчин хөгжинэ.
	4.4.Физикийн кабинетийн их засвар					69.600.000	Сурагчдын суралцах ая тухтай орчин бүрдэнэ.
	4.5.Физикийн кабинетийн тоног төхөөрөмж					25.500.000	Сурагчдын суралцах ая тухтай орчин бүрдэнэ.
	4.6.Хичээлийн байрны дээврийг хэсэгчилэн засах					25.000.000	Эрүүл, аюулгүй орчин бүрдэнэ
	4.7.Номын сангийн их засвар					35.000.000	Эрүүл, аюулгүй орчин бүрдэнэ
	4.8.ЕБС-н сэтгэл зүйн үйлчилгээний өрөөг стандартын дагуу тохижуулах /вакум өрөө/					15.500.000	Сэтгэл зүйн таатай орчин бүрдэнэ, Үйлчилгээ сайжирна.

<p>4.9.Дотуур байрны зөөлөн эдлэл/ гудас, хөгжил / Хөнжил 80ш - Нэг бүрийн үнэ 100,000 төгрөг 2. гудас 80ш - Нэг бүрийн үнэ 80,000 3. Ор хөнжлийн углаа даавуу 80ш - нэг бүрийн үнэ 80.000м төгрөг</p>					<p>20.800.000</p>	<p>Дотуур байрны сурагчдыг амьдрах таатай орчин нөхцөл бүрдэнэ</p>
<p>4.10.Сургуулийн "Урлаг зал"-ны их засвар</p>					<p>122.000.000</p>	<p>Сурагчдын авьяас, чадварыг хөгжүүлэх, сургалтын таатай орчин бүрдэнэ.</p>
<p>4.11.Дотуур байрны хүүхэд хөгжлийн өрөөнд суурийн компьютер-3 ширхэг өнгөт принтер-1 ширхэг хар принтер-1 ширхэг тус тус шаардлагатай</p>					<p>5.700.000</p>	<p>Эрүүл, аюулгүй орчин бүрдэнэ</p>
<p>4.12.Дотуур байранд нэн шаардлагатай өргөтгөлийн шатанд тор хийх</p>					<p>7.100.000</p>	<p>Аюулгүй орчин бүрдэнэ.</p>
<p>4.13.Дотуур байранд нэн шаардлагатай ус шүүгч-1 ширхэг, бүрэн автомат угаалгын машин-1 ширхэг зэрэг шаардлагатай</p>					<p>4.100.000</p>	<p>Эрүүл, аюулгүй орчин бүрдэнэ.</p>
<p>4.14.Дотуур байрны үүдний хэсэгт шаардлагатай тавилга, хэрэгсэл</p>					<p>3.200.000</p>	<p>Эрүүл, аюулгүй орчин бүрдэнэ.</p>
<p>4.15.Дотуур байр сургууль хооронд явган зам хийх</p>					<p>45.000.000</p>	<p>Эрүүл, аюулгүй орчин бүрдэнэ.</p>
<p>4.16.Бага ангийн сурагчдын "Хүүхэд хөгжлийн төв"-ийг тохижуулах</p>					<p>20.000.000</p>	<p>Сурагчдын авьяас, чадварыг хөгжүүлэх, сургалтын таатай орчин бүрдэнэ.</p>
<p>4.17.Англи хэлний preson хөтөлбөр хэрэгжүүлэх</p>					<p>5.100.000</p>	<p>Малчдын хүүхдийг англи хэл эзэмших</p>

								боломж бүрдэнэ
	4.18.Спорт заалны үүдний хэсгийн засвар, тохижуулалт						1.100.000	Сурагчдыг амьдралд сургах дадлагын бааз болгон хөгжүүлэх
	4.19.Хичээлийн байрны 1, 2 давхар модон шал солих						60.500.000	Эрүүл, аюулгүй орчин бүрдэнэ.
	4.20.Хичээлийн байрны босоо хэвтээ шугам их засвар						350.000.000	Эрүүл, аюулгүй орчин бүрдэнэ.
	4.21.Цахим анги тохижуулах						56.000.000	Сурагчдын авьяас, чадварыг хөгжүүлэх, сургалтын таатай орчин бүрдэнэ.
	4.22.Биологийн кабинетийн их засвар						69.600.000	Сурагчдын суралцах ая тухтай орчин бүрдэнэ.
	4.23.Биологийн кабинетийн тоног төхөөрөмж						25.500.000	Сурагчдын суралцах ая тухтай орчин бүрдэнэ.


ЕС:ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Хүрэх түвшин		Мэдээллийн эх сурвалж
				Он	Үзүүлэлт	Он	Үзүүлэлт	
1	Багш, ажилтны мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх, эрүүл мэндийг хамгаалах зорилтын хүрээнд	Мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан залуу багш	Хувь	2024	2	2028	100	Цэцэрлэгийн статистик мэдээ
		Туршлага судалж мэргэжил дээшлүүлсэн багш, ажилтан	Хувь	2024	-	2028	80	Цэцэрлэгийн статистик мэдээ
		Зохион байгуулсан хэлэлцүүлэг, зөвлөгөөн, уралдаан тэмцээн, чуулга уулзалт, үзэсгэлэн зэрэг арга хэмжээ	Тоо	2024	2	2028	4-6	Цэцэрлэгийн статистик мэдээ

		Хөтөлбөрийн хүрээнд зохион явуулах сургалт, түүнд хамрагдсан багш ажилтан	Тоо	2024	-	2028	10	Цэцэрлэгийн статистик мэдээ
		Багш ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулах	Хувь	2024	3	2028	60	Цэцэрлэгийн статистик мэдээ
		Эрүүл мэндийн чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо	Тоо	2024	2	2028	10	Цэцэрлэгийн статистик мэдээ
		Багшийн хөгжлийн төвийн орчин нөхцөлийг сайжруулах	Тоо	2024	-	2028	1	Цэцэрлэгийн багш хөгжлийн төв
2	Боловсролын үйлчилгээний үндсэн хэрэглэгч болсон хүүхдүүдийн сурч, хүмүүжин, хөгжих үндсэн хэрэгцээг хангах, тэдний үйл ажиллагаа, оролцоонд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд	Уралдаан тэмцээнд оролцож амжилт гаргасан хүүхдүүд	Тоо	2024	-	2028	20	Цэцэрлэгийн статистик мэдээ
		Дугуйлан секцийн тоо, хүүхдийн хамрагдалт	Хувь	2024	-	2028	50	Цэцэрлэгийн статистик мэдээ
		Тайлан тоглолт, бүтээлийн үзэсгэлэн гаргасан багш, сурагчдад	Тоо	2024	-	2028	4	Цэцэрлэгийн статистик мэдээ
3	Боловсролын үйлчилгээний оролцогч, дэмжигч субект болох эцэг эхийн идэвхи, оролцоог дэмжих зорилтын хүрээнд	Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаа	Тоо	2024	1	2028	4	Цэцэрлэгийн статистик мэдээ
		ОНО цэцэрлэг төсөл "Аавуудын оролцоо" "Ээжүүдийн оролцоо"	Хувь	2024	-	2028	40	Цэцэрлэгийн статистик мэдээ
		Эцэг эхийн дунд зохион явуулсан төрөл бүрийн уралдаан тэмцээн, сургал, хэлэлцүүлэг, зөвлөгөөн, үзүүлэх ажилд	Тоо	2024	10	2028	60	Цэцэрлэгийн статистик мэдээ
4	Багш, ажилтны нийгмийн баталгааг хангах, ажиллах нөхцлийг сайжруулах зорилтын хүрээнд	Батлагдсан журмын дагуу нийгмийн дэмжлэгт хамрагдсан багш, ажилтны тоо	Хувь	2024	15	2028	50	Цэцэрлэгийн статистик мэдээ
		Түрээсийн орон сууц, болон орон сууцны хөтөлбөрт хамрагдсан багш, ажилтан	Тоо	2024	-	2028	1-3	Цэцэрлэгийн статистик мэдээ

	Заах арга, ур чадвар, ажлын үр дүнгээр шалгарсан багш	Тоо	2024	5	2028	1-3	Цэцэрлэгийн статистик мэдээ
	Барилга байгууламжын засвар үйлчилгээ, гадна дотор тохжилт	Тоо	2024	2	2028	2-4	Цэцэрлэгийн статистик мэдээ

БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ



Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны
12 дугаар сарын 31-ний ээлжит III хуралдааны
09/11 тогтоолын хоёрдугаар хавсралт

**БОЛОВСРОЛ ХӨТӨЛБӨРИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2024.12.31

Жаргалант

№	Бодлого төлөвлөлтийн уялдаа	Зорилтын хэрэгжүүлэх хэмжээ арга	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үр дүнгийн үзүүлэлт		Санхүүжилт		Хариуцагч	
					Суурь түвшин	Зорилтот түвшин 2025	Санхүүжилт (Сая.төг)	Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал		
1. Багш, ажилтны мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр:										
1	АЗДУАХ 2.4.1.7	Сургууль, цэцэрлэгийн багш нарын мэргэжил арга зүйн "ТУРШЛАГА СУДЛАХ" үйл ажиллагааг зохион байгуулах. (Нийслэл, аймаг, сумдын сургууль, цэцэрлэг)	Мэргэжил арга зүйн туршлага судлах үйл ажиллагаа зохион байгуулах	Тоо	2024	2019 онд ЕБС "Боловсрол аялал-2019" 46 багш, ажилтан СӨБ 2023 онд УБ хотруу 14 багш, ажилтан туршлага судалсан	ЕБС, СӨБ туршлага судлах үйл ажиллагаа зохион байгуулах	3.0	ОНТ	ЕБС СӨБ
2	АЗДУАХ 2.4.1.7	'Чадварлаг багш' үзэсгэлэн гаргах	Үзэсгэлэн зохион байгуулах	Тоо	2024	-	20 багш оролцуулах	1.0	ЕБС төсөв	СӨБ ЕБС
2. Багшийн нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах чиглэлээр:										

3	АЗДУАХ 2.4.1.7	Улс, бүс чанартай тэмцээн байр эзэлсэн сурагчдад үзүүлэх	аймгийн олимпиад, уралдаанд багш, дэмжлэг үзүүлэх	Дэмжлэг үзүүлсэн багш, сурагч	Тоо	2024	2024 онд Би-Багш уралдаан, аймгийн болон улсын олимпиадад багш Б.Мөнгөнтуяа, Д.Есөнзаяа, Д.Ганцолмон нар амжилттай оролцсон	5 багш, 5 сурагч	1.0	ЕБС төсөв	ЕБС СӨБ
---	-------------------	---	--	-------------------------------------	-----	------	--	---------------------	-----	--------------	------------

ХОЁР: БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНДСЭН ХЭРЭГЛЭГЧ БОЛСОН СУРАЛЦАГЧДЫН СУРЧ ХҮМҮҮЖИН, ХӨГЖИХ ҮНДСЭН ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ, ТЭДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ОРОЛЦООНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ											
4	АЗДУАХ 2.4.1.3	Орон нутгийн түүхэн дурсгалт газар, ард иргэдийн ёс заншилтай танилцуулах зорилгоор ахлах ангид тусгай хөтөлбөрөөр “ЭКО” аяллыг зохион байгуулах	Хамрагдсан хүүхдийн тоо	Тоо	2024	2024 онд ангийн сурагч СӨБ 78 хүүхэд	7,8 ангийн сурагчид СӨБ-ийн хүүхдүүд 1 үйл ажиллагаа	0.5	ЕБС СӨБ төсөв	ЕБС СӨБ СӨБ	
5	ЗДУАХ 1.4.1.1	Хүүхдийн боловсролыг дээшлүүлэх “Design school” хөтөлбөр	Хамрагдсан хүүхдийн тоо	Тоо	2024	20	25 хүүхэд хамруулна.	20.0	ЗДТГ	ЕБС	

ГУРАВ. БАГШ АЖИЛТНЫ НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

1. Хөрөнгө оруулалт											
6	АЗДУАХ 2.4.1.2 ЖСМАНМ Х 1.2.6	Бага ангийн сурагчдын “Хүүхэд хөгжлийн төв”-ийг тохижуулах	Ажлын гүйцэтгэл, чанар	Тоо	2024	2024 онд ОНТ-аар багш хөгжлийн төвийг стандартын дагуу тохижуулах ажлын хүрээнд 10 ширхэг шүүгээ хийгдсэн	100%	20.0	ОНТ	ЕБС	

7	Мэдээллийн технологийн кабинетын их засвар	Ажлын гүйцэтгэл, чанар	Тоо	2024	2005 онд их засвар ТСБ-ийн тусламжаар хийгдсэн. 50%	Их засвар 100%	80.0	ОНТ	ЕБС
8	Мэдээллийн технологийн кабинетэд шаардлагатай тоног төхөөрөмж	Ажлын гүйцэтгэл, чанар	Тоо	2024	2014 онд ОНХО 12ш компьютер	Шаардлагатай тоног төхөөрөмж 100%	70.0	ОНТ	ЕБС
9	Дотуур байр, сургууль хооронд явган хүний зам тавих	Ажлын гүйцэтгэл, чанар	Тоо	2024	Монгол улсын стандартын MNS 6056: 2009 дагуу хийх	100%	45.0	ОНТ	ЕБС
10	Дотуур байрны хүүхдийн стандартын шаардлага үүднээс зөөлөн худалдан авах	Ажлын гүйцэтгэл, чанар	Тоо	2024	2020 онд улс, аймаг сумын 12 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар зөөлөн эдлэл нийлүүлэгдсэн.	Дотоодын үйлдвэрийн зөөлөн эдлэл Гудас-80ш Хөнжил-80ш Цагаан хэрэглэл-80 ширхэг 100%	19.7	ОНТ	ЕБС
11	Цэцэрлэгийн бохирын шугам солих, урсгал засвар хийх /Зураг төсөв гарсан/	Ажлын гүйцэтгэл, чанар	Тоо	2024	50%	100%	140.0	ОНТ	СӨБ
12	Цэцэрлэгийн хүүхдийн ор (150 ширхэг ор)	Ажлын гүйцэтгэл, чанар	Тоо	2024	55%	150 ширхэг ор нийлүүлэгдсэн байх	14.8	ОНТ	СӨБ
13	Цэцэрлэгийн хүүхдийн ширээ сандал (36 ширхэг ширээ, 150 ширхэг сандал)	Ажлын гүйцэтгэл, чанар	Тоо	2024	50%	, сандал ширээ	7.7	ОНТ	СӨБ

14	А3 принтер-1ш	Ажлын гүйцэтгэл, чанар	Тоо	2024	40%	Хэвлэлт: Өнгөт цаасны хэмжээ: А4 Төрөл: Inkjet 2 талаар хэвлэх: DUP LEXING 100%	1.5	ОНТ	СӨБ	
15	Боловсрол хөтөлбөрийн спортуугаагч худалдан авах	Ажлын гүйцэтгэл, чанар	то	2024	-	100%	20.0	ОНТ	ЗДТ Г	
							3 зорилт, 15 арга хэмжээ 2.500.000 ЕБС, СӨБ ТӨСӨВ 441.7 сая ОНТ			

ЖАРГАЛАНТ СУМЫН ЕБС, ЦЭЦЭРЛЭГ